



НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү бодлогын зорилго нь БИД БЭСБ ХХК (цаашид “Компани” гэх)-ийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ашигт ажиллагааны түвшин, төлбөрийн чадварыг дээшлүүлэх, байгууллагын стратеги төлөвлөгөөг бүрэн ханган биелэхүйц байдлаар хувьцаа эзэмшигчдэд хувиарлах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хувиарлахтай холбоотой шийдвэр гаргах, энэ талаарх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийн төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Бодлого нь Компанийн тухай хууль, Компаний дүрэм, зохицуулагч байгууллагаас гаргасан журмуудад нийцсэн бөгөөд Компаний ногдол ашиг хувиарлах, төлөх ажиллагаанд дээрх хууль, дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллана.

ХОЁР. НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

- 2.1 Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг ТУЗ тодорхойлно.

ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХ НӨХЦӨЛ

- 3.1 ТУЗ цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:

3.1.1 Ногдол ашиг төлсний дараа байгууллага төлбөрийн чадвартай байх;

3.1.2 Ногдол ашиг нь цэвэр ашгийн 40%-иас ихгүй байх;

3.1.3 Стратеги төлөвлөгөөг бүрэн ханган биелэхэд өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай байх,

3.1.4 Ногдол ашиг төлсний дараа байгууллагын өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР

4.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнан мэдэгдэх.

4.3 Компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ашигт ажиллагааны түвшин, чадвахийг дээшлүүлэх шаардлагын үүднээс ТУЗ-ийн шийдвэрээр тодорхой хугацаанд ногдол ашгийг хувиарлахгүй байж болно.

4.4 ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо байгууллагын бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

ТАВ. ТАЙЛАГНАХ

5.1 Ногдол ашиг төлсөний дараа компанийн санхүүгийн тайланд холбогдох хуульд заасны дагуу тусгана.

5.2 Ногдол ашиг тараасны дараа үлдэх ашгаас нийгмийн хариуцлага, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг гүйцэтгэх удирдлага боловсруулж, ТУЗ-ийн тогтоолоор батална.